



АВСТРАЛИ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

Захиргааны эрх зүйн маргаан¹

ДАВХАР ТАТВАРЫН ГЭРЭЭТЭЙ БОЛ ИРГЭНШЛЭЭР ЯЛГАВАРЛАХГҮЙ ТАТВАР НОГДУУЛНА

САНАМЖ: Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад болон олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын шүүхийн шийдвэр болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: S25/2021

Шүүхийн шийдвэрийн огноо: 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр

Шийдвэрийн төлөв: Австрали Улсын Дээд шүүхээс нэхэмжлэгчийн давж заалдах гомдлыг зардлын хамт хангаж, Австрали Улсын Холбооны шүүхийн давж заалдах шатны шүүх бүрэлдэхүүний 2020 оны 08 дугаар сарын 06-нд гаргасан шийдвэрийн 1 болон 3 дугаар заалтыг хүчингүй болгожээ.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Нэхэмжлэгч нь Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын иргэн бөгөөд 2015 оны 07 дугаар сарын 03-нд Австрали Улсын Цагаачлалын тухай хуулийн² дагуу Working Holiday (Temporary) (Class TZ) (Subclass 417) виз (цаашид “ажиллах болон амрах виз” гэх) хүсэн өргөдөл гаргажээ. Австрали Улсаас түүнд виз олгож, тэрээр 2015 оны 08 дугаар сараас 2017 оны 05 дугаар сар хүртэлх хугацаанд Австрали Улсад амьдарч, ажилласан. 2017 оны орлогын жилд тэрээр Сидней хотод нэгэн рестораны зөөгчөөр түр ажиллаж, \$26,576 хэмжээний татвар ногдох орлого олжээ.

2016 оны 12 дугаар сард ажиллах болон амрах виз эзэмшигчдэд хамаарах татварын хувь хэмжээг шинэчилж, Орлогын албан татварын хувь хэмжээний тухай хуулийн³ 7 дугаар Хавсралтад шинэ III хэсгийг нэмж, 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш олсон орлогод хэрэгжүүлэхээр баталсан байна. Тус III хэсгээр хувь хүний “ажиллах болон амрах визээр ажиллаж олсон татвар ногдох орлого”-ын эхний \$37,000-д 15 хувийн тогтмол татвар ногдуулж, татвар төлөх үүргийн дээд хэмжээг \$5,550 болгосон. Харин 7 дугаар Хавсралтын I хэсгийн дагуу ижил хугацаанд ижил эх үүсвэрээс орлого олсон Австрали Улсын иргэний татварын ачааллыг бага байхаар тооцоолж, тэд эхний \$18,200-д татвар төлөхгүй, дараагийн \$37,000 хүртэл орлогод 19 хувийн татвар төлөхөөр байсан бөгөөд татвар төлөх үүргийн дээд хэмжээг \$3,572 байхаар хуульчилжээ.

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр үзэх холбоос: <https://www.hcourt.gov.au/cases-and-judgments/judgments/judgments-1998-current/addy-v-commissioner-taxation>, (Сүүлд үзсэн: 2026.01.16).

² Migration Act (1958), Австрали Улсын Цагаачлалын тухай хууль, https://www.austlii.edu.au/cgi-bin/viewdb/au/legis/cth/consol_act/ma1958118/, (Сүүлд үзсэн: 2026.01.16).

³ Income Tax Rates Act (1986), Австрали Улсын Орлогын албан татварын хувь хэмжээний тухай хууль, https://www.austlii.edu.au/cgi-bin/viewdoc/au/legis/cth/consol_act/itra1986174/index.html, (Сүүлд үзсэн: 2026.01.16).



2017 оны 12 дугаар сарын 20-нд Татварын комиссар нэхэмжлэгчид хандан 2017 оны орлогын жилд нэмэлт үнэлгээний мэдэгдэл гаргаж, 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойшхи орлогод 7 дугаар Хавсралтын III хэсгийн заалтыг хэрэглэсэн. Харин нэхэмжлэгчийн зүгээс III хэсгийн заалтыг түүний орлогод хэрэглэх нь Их Британийн конвенцын 25(1) дүгээр зүйлийг зөрчсөн гэж гомдол гаргасан бол Татварын комиссар нэхэмжлэгчийг 2017 оны орлогын жилд хамаарах Австрали Улсын татварын зорилгоор оршин суугч мөн гэж, Rates Act-ийн 3A зүйлд заасан “working holiday maker”⁴ гэж тус тус үзэн, уг гомдлыг хэрэгсэхгүй болгон III хэсгийн татварын хувь ногдох ёстой гэж дүгнэжээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

Анхан шатны шүүхээс:⁵ Австрали Улсын Орлогын албан татварын хувь хэмжээний тухай хуулийн 7 дугаар Хавсралтын III дахь хэсэгт заасан татварын хувь хэмжээнүүд нь нэхэмжлэгчийг харьяаллаар ялгаварлан гадуурхсан бөгөөд энэ нь Их Британийн конвенцын 25(1) дүгээр зүйлийг зөрчсөн гэж дүгнэсэн. Иймд уг хэргийг нэмэлт үнэлгээ)amended assessment(хийлгэхээр Татварын комиссарт буцааж шийдвэрлэсэн.

Үндэслэл нь нэхэмжлэгчийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Австрали Улсаас явсан 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх олсон орлогод тус хуулийн 7 дугаар Хавсралтын III дахь хэсэгт заасан татварын хувь хэмжээг хэрэглэхгүй, харин Орлогын албан татварын үнэлгээний тухай хууль⁶)1936 оны(-ийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу түүнийг “оршин суугч албан татвар төлөгч” гэж үзэн дахин татвар ногдуулах орлогыг тодорхойлохыг үүрэг болгожээ.

Давж заалдах шатны шүүхээс:⁷ Хариуцагч болох Татварын комиссарын давж заалдах гомдлыг Австрали Улсын Холбооны давж заалдах шатны шүүхийн бүрэлдэхүүн олонхийн саналаар хангаж шийдвэрлэсэн. Ингэхдээ шүүх нэхэмжлэгчийг Их Британи Улсын иргэн учраас бус, харин визний нөхцөлүүдийг хангасан учраас виз эзэмшсэн бөгөөд ийнхүү виз эзэмшиж байгаа нь иргэншлийн “зайлшгүй үр дагавар” биш, өөрөөр хэлбэл нэхэмжлэгчийн иргэншлээс шалтгаалж татварын илүү дарамттай байдал үүсээгүй гэж үзсэн.

Түүнчлэн, Их Британийн конвенцын 25(1) дүгээр зүйлийг тайлбарлан хэрэглэхдээ “ажиллах болон амрах виз”-ийг эзэмших нь татварын тодорхой нөхцөл учраас иргэншлээс шууд шалтгаалсан ялгаварлал гэж үзэх боломжгүй, нэхэмжлэгчийн эзэмшиж буй визийн төрлөөс шалтгаалж түүнд татварыг ялгаатай

⁴ Ажиллаж, амрах визтэй гадаадын иргэн

⁵ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр үзэх холбоос: <https://www.austlii.edu.au/cgi-bin/viewdoc/au/cases/cth/FCA/2019/1768.html>, (Сүүлд үзсэн: 2026.01.16).

⁶ Income Tax Assessment Act (1936), Австрали Улсын Орлогын албан татварын үнэлгээний тухай хууль, https://www6.austlii.edu.au/cgi-bin/viewdb/au/legis/cth/consol_act/itaa1936240/, (Сүүлд үзсэн: 2026.01.16).

⁷ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр үзэх холбоос: <https://www.austlii.edu.au/cgi-bin/viewdoc/au/cases/cth/FCAFC/2020/135.html>, (Сүүлд үзсэн: 2026.01.16).



ногдуулахаар шийдвэрлэсэн тул энэ нь конвенцын дурдсан заалтыг зөрчөөгүй гэж үзсэн.

Нэхэмжлэгч Австрали Улсын Дээд шүүхэд гаргасан гомдолдоо:

Нэхэмжлэгчийн зүгээс Австрали Улсын Холбооны давж заалдах шатны шүүх хэргийг шийдэхдээ Их Британи-Австралийн татварын гэрээний 25(1) дүгээр зүйлийн дагуу түүнийг хөнгөлөлт эдлэх ёсгүй гэж үзсэн нь хууль зүйн алдаа байсан гээд үндэслэлээ нэгдүгээрт, 25(1) дүгээр зүйл нь зөвхөн иргэншлээр ялгаварласан татварыг хориглох агуулгаар хязгаарлагдахгүй (өөрөөр хэлбэл уг заалт нь гарал угсаа зэрэг бусад үндэслэлээр ялгаварласан татварыг ч хориглоно), хоёрдугаарт, ямар ч тохиолдолд Орлогын албан татварын хувь хэмжээний тухай хуулийн 7 дугаар Хавсралтын III хэсэг нь Их Британийн конвенцын 25(1) дүгээр зүйлийг зөрчин зөвхөн иргэншлээр ялгаварласан татвар тогтоосон гэж маргасан.

Австрали Улсын Дээд шүүхээс: Нэхэмжлэгчийн давж заалдах гомдлыг зардлын хамт хангаж шийдвэрлэв. Энэ хэрэгт маргаангүй тогтоогдсон нөхцөл байдал нь нэгдүгээрт, нэхэмжлэгч нь Их Британийн иргэн мөн, хоёрдугаарт 2017 оны орлогын жилд Австралийн “оршин суугч албан татвар төлөгч” байсан, гуравдугаарт Орлогын албан татварын хувь хэмжээний тухай хуулийн 7 дугаар Хавсралтын III дахь хэсэгт заасан татварын хувь хэмжээ нь Австрали Улсын оршин суугч иргэдэд ногдох татвараас илүү өндөр байсан.

Шүүх дүгнэхдээ нэхэмжлэгч нь Австралийн иргэнтэй ижил төрлийн ажил хийж, ижил эх үүсвэрээс, адил хэмжээний орлого олсон боловч түүнд Австралийн иргэнээс илүү өндөр хувь хэмжээгээр татвар ногдуулсан нь түүний иргэншлээс шалтгаалсан тул Их Британийн конвенцийн 25(1) дүгээр зүйлийг⁸ зөрчсөн гэж үзэв.

Австрали болон Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсууд нь “Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай” конвенцын оролцогч улсууд (“Их Британийн конвенц”) бөгөөд уг конвенц нь 2003 оны 12 дугаар сарын 17-нд хүчин төгөлдөр болж, Австрали Улсын дотоодын хуульд тусгагджээ.

25(1) дүгээр зүйл нь ердийн утгаараа, Их Британийн иргэнийг иргэншлээс бусад нөхцөл, байдал ялангуяа оршин суугаа байдлын хувьд, ижил нөхцөлд байгаа Австралийн иргэнтэй харьцуулахыг шаарддаг. Энэ хэрэгт, нэхэмжлэгч нь Австралийн “оршин суугч албан татвар төлөгч” байсан.

Хариуцагч болох Татварын комиссарын тайлбараар, Цагаачлалын тухай хуулийн 29 дүгээр зүйлд Австралийн иргэнийг ажиллаж, амрах виз эзэмшихийг хориглодог тул 25(1) дүгээр зүйлийн шаардсан харьцуулалтыг хийх боломжгүй. Комиссар уг тайлбараа батлахын тулд Шинэ Зеландын Давж заалдах шатны шүүхийн Commissioner of Inland Revenue v United Dominions Trust Ltd хэргийг эш татсан. Тус хэрэгт, “ижил нөхцөлд” гэдэг нь иргэншлээс бусад бүх холбогдох

⁸ Их Британийн иргэдийг Австралид “ижил нөхцөлд, ялангуяа оршин суугаа байдлын хувьд ижил” үед Австралийн иргэдэд ногдуулж буй татвараас “өөр эсхүл илүү өндөр хувь хэмжээтэй” татвар ногдуулах ёсгүй.



асуудлаар “бараг ижил нөхцөл”-ийг илэрхийлнэ гэж үзэж, “same” гэдэг үг нь харьцуулалтад “нэгэн жигд байдал, яг адил байдал”-ыг илтгэнэ гэж тайлбарласан. Тухайн хэрэгт Их Британид бүртгэлтэй, Их Британийн иргэншил, оршин суугаа байдалтай компанид ногдуулсан илүү татвар нь иргэншлээс бус, харин оршин суугаа байдлаас шалтгаалсан тул ялгаварлалт биш гэж дүгнэсэн.

Дээд шүүхээс татварын комиссарын United Dominions Trust хэргийг эш татсан тайлбар нь үндэслэлгүй гэж үзсэн, учир нь дээр дурдсан хэргийг шийдвэрлэсэн шүүх хэргийг шийдвэрлэхдээ “илүү төлүүлж буй татвар нь иргэншлээс бус, харин оршин суугаа байдлаас шалтгаалсан тул ялгаварлан гадуурхалт биш” гэж дүгнэсэн байв. Их Британийн конвенцын хувьд ч мөн адил гадаадын иргэн нь “оршин суугч бус албан татвар төлөгч” байх тохиолдолд илүү өндөр хувь хэмжээгээр татвар ногдуулахыг зөвшөөрдөг тул хэрэв нэхэмжлэгч нь оршин суугч бус татвар төлөгч байсан бол энэхүү маргаанд конвенцын 25)1(дүгээр зүйл хэрэглэгдэхгүй.

Гэвч энэ хэрэгт комиссар өөрөө нэхэмжлэгчийг Австралийн “оршин суугч албан татвар төлөгч” гэж хүлээн зөвшөөрсөн байдаг. Энэ хэргийн тухайд татвар ногдуулах суурь болон үнэлэх арга ижил байсан боловч татварын хувь хэмжээ ижил байгаагүй. Нэхэмжлэгч Их Британийн иргэнд татвар ногдуулж буй хувь хэмжээ нь ижил нөхцөлд орлого олсон Австралийн иргэний төлөх татвараас өндөр байсан тул түүний гомдлыг дээрх үндэслэлүүдээр хангаж шийдвэрлэжээ.

Хураангуй бэлтгэсэн: Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны
шүүхийн шүүгч Г.Урангуа

---o0o---